



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 06

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын бараа материалаас сонгож аудитын явцад биет тооллого хийхэд 2017 оны 7-8 дугаар сард ашигласан 3352,5 мянган төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг борооны пуужинг зарлагадаагүй, санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгаж, тооллогын бүртгэлд бодитоор оршин байгаагаар илэрхийлсэн.

2. 2017 оны 07 дугаар сард улирлын чанартай ажил эрхэлдэг 3 ажилтны цалин, түүнтэй адилтгах орлогыг 240.0 мянган төгрөгөөр мэдээлсэн атлаа ажил олгогчоос төлөх НДШ-ийг мэдээлээгүй, тайлант онд 3 ажилтны цалинг нийгмийн даатгалын мэдээнд 150.0 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн, ХХОАТ-ын цахим тайлангийн өглөг, аудитаар тооцсон өглөгөөс 877.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

3. 2017 оны 03 сард зохион байгуулсан сургалтын томилолтын зардалд 2044.1 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” зэрэг заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль

2517117

тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зарцуулсан тухай бүрт бүртгэлээс хасаагүй 3352,5 мянган төгрөгийн 10 ширхэг борооны пуужинг холбогдох анхан шатны баримтыг үндэслэн баталгаажуулж зарлагадах, ажиллагсдын цалинг үнэн зөв мэдээлэх, сургалтын томилолтын анхан шатны баримтыг бүрдүүлж, баримтад хавсаргаж аудитаар илэрсэн 6,503,057 төгрөгийн зөрчлийг арилгах

2. Албан шаардлагын биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт 2018.05.20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын төсвийн захирагч Л.Мандал, нягтлан бодогч Э.Амарбаясгалан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР  Б.ДОЛЖМАА

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  Л.МАНДАЛ

НЯГТЛАН БОДОГЧ  Э.АМАРБАЯСГАЛАН



. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 16

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баян-Овоо сумын ИТХ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналыг тулган шалгахад 2015.12.31-ний өдөр хөрөнгөд орлогод авсан 39507.5 мянган төгрөгийн 6 үндсэн хөрөнгийн ашиглах жилийг -1 жилээр авснаас шалтгаалж, үндсэн хөрөнгөд элэгдэл тооцоогүй.

Мөн үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 4620.0 мянган төгрөгийн шигшээ багийн тамирчны хувцасыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 4.78-т заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

2517139



1. Ашиглах жилийн -1 жилээр санхүүгийн программд оруулсан үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулж, элэгдлийг санхүүгийн тайланд үнэн зөв илэрхийлэх.
2. Үндсэн хөрөнгөөс холбогдох анхан шатны баримтыг үндэслэн 4620,0 мянган төгрөгийн тамирчны хувцасыг хасах
3. Албан шаардлагын биелэлтийг 2018.05.20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Мөнхзул , нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

	ӨГСӨН¹:	
АХЛАХ АУДИТОР		Б.ДОЛЖМАА
	ЗӨВШӨӨРСӨН:	

Б.404008 9007-23

БАЯН-ОВОО СУМЫН ИТХ-ЫН

		
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	Б.МӨНХЗУЛ	
НЯГТЛАН БОДОГЧ		Б.ҮЛЭМЖСОНИН

БГАБС 082314

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 26

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баянбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 2000.0 мянган төгрөгийн 20 ширхэг ариутгалын хувцас, 1080.0 мянган төгрөгийн 4 ширхэг нум, сум, 11000.0 мянган төгрөгийн гэрэлтүүлгийн ажлыг санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй.

2. Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 9570.0 мянган төгрөгийн үнэ бүхий мал бойны цэг, 7350.6 мянган төгрөгийн малын хашааг нэгтгэж сумын ЗДТГ-ын хөрөнгөд орлогод авахдаа 1029.3 мянган төгрөгөөр илүү дүнгээр орлогод бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**


2518009

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 14,080,000 /Арван дөрвөн сая наян мянган/ төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудад орлогоор үнэн зөв бүртгэж, 2018 оны эхний улирлын санхүүгийн тайланд залруулах.

2. Сумын ЗДТГ-т зөрүүтэй бүртгэсэн малын бойны цэг, малын хашааны үнийг 1,029,399 /Нэг сая хорин есөн мянга гурван зуун ерэн есэн мянган/ төгрөгөөр залруулж бүртгэх

3. Албан шаардлагын биелэлтийг 2018.05.20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянбулаг сумын Засаг дарга Р.Жамьяндорж, нягтлан бодогч Ч.Эрдмаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР	ӨГСӨН¹: 	Б.ДОЛЖМАА
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ	ЗӨВШӨӨРСӨН: БН-040067 9007423 	Р.ЖАМЬЯНДОРЖ
НЯГТЛАН БОДОГЧ		Ч.ЭРДМАА

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.